



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЛУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 4/29

Баянхошуу

Төрийн албан хаагчдын албан тушаалын
тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.1, 5.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрснөөр Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 2 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр Нийгмийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 3 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр хөдөө аж ахуйн тасгийн хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 4 дүгээр хавсралтаар зөвшөөрснөөр Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 5 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 6 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг, 7 дугаар хавсралтаар зөвшөөрснөөр төсөв төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг тус тус баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог сайтар хангаж ажиллахыг нийт төрийн албан хаагчдад анхааруулсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АЛТАНТУЯА

642422017